

Ерөнхий боловсролын газарт

Танай яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн дэргэд ажлын хэсэг томилогдож Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн 7000 орчим овог нэрийг 2021 оны 04 сарын 22-29-ийн хооронд монгол бичигт хөрвүүлж жигдлэв. Төгсөгчдийн овог нэрийг хөрвүүлэхэд баримталсан зарчмыг хавсаргав.

1. Төгсөгчдийн нэрийг монгол бичигт хөрвүүлэхдээ Ш.Чоймаа нарын “Монгол хүний нэрийн толь”-ийг баримтлан бичив. Толь дахь засах шаардлагатай зарим нэр, тольдо ороогүй нэрсийг хэрхэн бичсэн талаарх зарчмыг доор дэлгэрүүлэн тайлбарлая.
2. “Очир” гэдэг нэрийг монгол бичгээр “ ᠣᠴᠢᠷ ” хэмээн гийгүүлэгчээр эхэлж бичдэг тул нийлмэл нэрд залгаж бичнэ. Жишээлбэл, Аз-Очир ᠠᠵᠤᠣᠴᠢᠷ .
3. “Ёндон, Янжин” зэрэг “Я-ийн төрлийн үсэг”-ээр эхэлсэн нэрсийг нийлмэл нэрд залгаж бичнэ. “Я-ийн төрлийн үсэг”-ийг эгшгийн өмнө тохиолдвол гийгүүлэгчид тооцдог тул тийнхүү залгаж бичнэ. Жишээлбэл, Бадам-Ёндон ᠪᠠᠳᠠᠮᠢᠶ᠋ᠢᠨᠳᠣᠨ , Дэнзэн-Янжин ᠳᠡᠨᠵᠡᠨᠢᠶ᠋ᠢᠨᠵᠢᠨ гэх мэт.
4. Дуудах эгшигтэй үгийн хэлбэр бүхий нэр буюу “Цэцэгээ, Зоригоо” гэх мэт нэрд орхиц нэмж бичихгүй байх зарчмыг барив. Гагцхүү сүүл “н” үсгээр төгссөн нэрийн дуудах эгшигтэй хэлбэрийг илүү тогтсон, нийтлэг хэлбэр гэж үзэн орхицтой бичив. Жишээ нь, Ариунаа - ᠠᠷᠢᠭᠤᠨᠠᠭᠠ .
5. Бага инхлэг буюу сүүл “н” үсгээр төгссөн нэрд “н, х, г” гийгүүлэгчээр эхэлсэн нэр залгаж, нийлмэл нэр бүтээсэн тохиолдолд “н” үсгийг их инхлэг болгодог ба хэвээр бичдэг хоёр заншил уламжилж иржээ. Монгол бичигт үгийн үндсийг үл эвдэх зарчим чухал хэдий ч сүүл “н” үсгийн араас эр үгийн “х, г” үсэг залгаж ороход дараалсан олон шүд болж буруу дуудах магадлалтай (эр үгийн “г, х” үсэг үгийн дунд шүдээр бичигддэг) тул бид нийлмэл нэрийн хоёр дахь нэр нь “г, х” үсгээр эхэлсэн нэр орвол өмнөх бага инхлэгийг их инхлэг болгож бичив. Харин “н” үсэг болон эм үгийн “х, г” үсгээр эхэлсэн нэрсийг шууд залгаж бичихээр тогтов. Энэ тохиолдолд буруу унших, дуудах магадлал бага гэж үзэв. Жишээлбэл, Алтангаа ᠠᠯᠲᠠᠨᠭᠠᠭᠠ , Арвингэрэлт ᠠᠷᠪᠢᠨᠭᠡᠷᠢᠯᠲᠦ , Билгүүнхутаг ᠪᠢᠯᠭᠡᠭᠦᠨᠬᠤᠲᠤᠭᠠ , Номунхишиг ᠨᠣᠮᠤᠨᠬᠢᠰᠢᠭᠢ , Оюунномингэрэл ᠣᠶᠤᠨᠨᠣᠮᠢᠨᠭᠡᠷᠢᠯ гэх мэт.
6. Гадаад нэрд бага инхлэг буюу сүүл “н” үсгийн араас “н, х, г” гийгүүлэгчээр эхэлсэн нэр залгаж, нийлмэл нэр бүтээсэн тохиолдолд буруу унших, хөрвүүлэх магадтай тул хоёр нэрийн хоорондох нурууг нэг шүдний хэртэй уртхан татахаар тогтов. Учир нь гадаад нэрд бага инхлэгийг их инхлэг болговол уг нэртэй ойролцоо бичлэг, дуудлагатай их инхлэгээр бичигдэх нэр байж магадгүй бөгөөд түүнтэй андуурах магадлалтай хэмээн үзэв. Жишээлбэл, Күннур ᠬᠦᠨᠨᠦᠷ , Аргынгазы ᠠᠷᠭᠢᠨᠭᠠᠵᠢ , Айланхан ᠠᠶᠢᠯᠠᠨᠬᠠᠨ гэх мэт.
7. “Билиг, Бэлгэ, Бэлэг” хэмээх дуудлага ойролцоо нэрсийн утгыг нь харгалзаж хөрвүүлэв.
8. “Данзан-Орги, Пүрэв-Ориг” – Орги, Ориг гэх нэрийг төвөд нэртэй хамт орвол төвөд хэлний “хань нөхөр” гэсэн утгатай “ ᠶ᠋ᠣᠭ рог” гэх үг хэмээн үзэж “ ᠣᠷᠭᠢ ” гэж бичив.
9. “Балт-Орги” гэдэг нэрийг монгол хэлний “Оргих” гэдэг үгийн язгуур хэмээн үзэж “ $\text{ᠪᠠᠯᠲᠤ} - \text{ᠣᠷᠭᠢ}$ ” гэж бичив.

10. Додхүү, Додьгүү – “ᠳᠣᠳᠦᠬᠦᠭᠦᠨᠠᠳᠦᠳᠦᠬᠦᠭᠦᠨ” есөн хүсэл гэсэн утгатай төвөд нэр тул “ᠳᠣᠳᠦᠬᠦᠭᠦᠨ” гэж бичив.
11. Чамба, Чимбий, Чомбо, Чумба гэх нэрс нь төвөд хэлний “их” гэсэн утгатай “ᠴᠢᠮᠪᠠ” гэж бичив.
12. “Ерөө” гэдэг нэрийг “Монгол хүний нэрийн толь”-д “ᠶᠡᠷᠡᠭᠡ” гэж бичсэнийг засаж “ᠶᠡᠷᠡᠭᠡ” гэж бичив.
13. “Загджүүсэн” гэдэг нэрийг “Загдзүсэм” гэдэг нэрийн сунжирсан дуудлага гэж үзэв.
14. Иш хэмээх “Монгол хүний нэрийн толь”-д “ᠶᠢᠰ” гэж бичсэн боловч бид хуучин уламжлалаа дагаж “ᠶᠢᠰ” хэмээн бичив.
15. “Лхагважамцан, Чойжамцан” гэдэг нэрс дэх “Жамцан”-ыг “Жанцан” гэдэг нэрийн хувилбар гэж үзэв.
16. “Маналай” гэдэг нэрийг “Манлай” гэдэг нэрийн буруу бичсэн хувилбар гэж үзэв.
17. “Мандал” гэдэг нэр нь санскрит болон монгол хоёр хувилбар бий. Санскрит болон төвөд нэртэй хамт орвол санскрит “ᠮᠠᠨᠳᠠᠯ”, монгол нэртэй хамт орвол монгол хэлний мандах үйлийг заасан “ᠮᠠᠨᠳᠠᠯ” гэдэг үгээр бичив.
18. “Анулан, Анулин, Анулэн, Номчулан, Номчулин, Хануулан, Эрмүүлэн, Эрхлүүн” гэх нэрсийн “-лан, -лин, -лэн” төгсгөлийг хүний нэрд түгээмэл тохиолддог “-лун, -лүн” дагавраар бичив.
19. “Октябрь” гэдэг нэрийг монгол бичгээр бичихэд “я” үсгийн өмнө “шилбэ” нэмж бичдэг байснаас татгалзаж, “ᠶᠡᠬᠡᠮᠢᠵᠡᠷ” гэж бичив. Гийгүүлэгчийн араас шууд “я” залгасан “Коля, Таня” гэх мэт нэрсийг ч энэ зарчмаар бичив.
20. “Пүрвүүдагуу” гэдэг нэрийг “Пүрэвдагва” гэдэг нэрийн сунжирсан дуудлага хэмээн үзэв.
21. “Раадансүх” гэдэг нэрийг “Раднаасүх” гэдэг нэрийн хувилбар гэж үзэв.
22. “Роланмаа” гэдэг нэрийг “Ролмаа” гэдэг нэрийн сунжирсан дуудлага гэж үзэв.
23. “Санжсүрэн, Санжпүрэв” гэх мэт нэрийн эхний хэсэг болох “Санж”-ийг тольд “ᠰᠠᠩᠵᠢ” хэмээн бичсэнийг даган “ᠰᠠᠩᠵᠢᠰᠦᠷᠢᠨ, ᠰᠠᠩᠵᠢᠫᠦᠷᠡᠪ” гэхчлэн бичив. Гагцхүү “Санжмятав” гэдэг нэрийг “ᠰᠠᠩᠵᠢᠮᠢᠲᠠᠪ” гэж бичив. Энэ нэрийн гарал нь өмнөх “Санж”-аас өөр учир гарлыг барьсан болно.
24. “Симбаасүрэн, Сияанямбуу” гэдэг нэрсийг “Сэмбаасүрэн, Саяинямбуу” гэдэг нэрсийн хувилбар гэж үзэв.
25. “Сэндмэн” гэдэг нэрийг “Зэндмэнэ” гэдэг нэрийн хувилбар хэмээн үзэв.
26. “Хилийнчимэг” гэдэг нэрийн монгол бичгээр шууд бичвэл гурван шилбэ дараалан орж монгол бичгийн зөв бичих зүйн зарчмыг зөрчих тул нэг шилбийг нь хурааж “ᠬᠢᠯᠢᠶᠢᠨᠴᠢᠮᠡᠭ” гэж бичив.
27. “Хөөнхуяг” гэдэг нэрийг монгол бичгийн зөв бичлэгийг дагаж “ᠬᠡᠭᠡᠨᠬᠡᠭᠠᠢᠭ” гэж бичив.
28. “Цэндэнжав” гэдэг нэрийг “Сэндэнжав” гэдэг нэрийн хувилбар гэж үзэв.
29. “Чимэдроолон, Чимэдроолом” гэдэг нэрийг “Чимэдролмаа” нэрийн хувилбар гэж үзэв.
30. “Чоно” гэдэг нэрийг тольд “ᠴᠣᠨᠣ”, нийлмэл нэрд “ᠴᠣᠨᠣᠰ” гэж бичжээ. Гэвч бид энэхүү нэрсийг бичихдээ “Чонос” овгийн нэрийг “ᠴᠣᠨᠣᠰ” хэмээн төгсгөлийн

- орхицыг гээж бичдэг уламжлалыг дагаж бичив. Жишээ нь, Чонохүү “ᠴᠣᠨᠣᠬᠦ”, Чонодэлэг “ᠴᠣᠨᠣᠳᠡᠯᠡᠭ”.
31. “Чөрхи” гэдэг нэрийг түүхэн сурвалжид тохиолдох Амудай чөрхи хунтайжийн нэрийн бичлэгийг баримтлав.
 32. “Шарав, Шийрэв” гэдэг хоёр нэр нь төвөд хэлний “билиг” гэсэн утгатай “ᠰᠢᠷᠠᠪᠠ” - шэйрав” хэмээх үгийн хоёр өөрөөр дуудсан хувилбар юм. Энэ хоёр нэрийн тухайд тогтсон уламжлалыг даган “ᠰᠢᠷᠠᠪ” гэж бичив. Энэ хоёр нэрээс бусад “ᠰᠢᠷᠠᠪ” - шэй” ялгуураас үүссэн “Шийлэг, Шийтэр” гэх мэт нэрсийг “ᠰᠢᠷᠠᠪ” гэж бичив.
 33. “Шунайхүү” гэдэг нэрийг “Шонуухүү” нэрийн хувилбар гэж үзэв.
 34. Монгол хүний зарим нэрийг кирилл үсгээр олон янз хувилбараар бичдэгийг “Монгол хүний нэрийн толь”-д гарлыг нь барин, нэг хувилбараар жигдэлсэн байдаг. Энэ зарчмаар Казах нэрийн олон хувилбараас казах хэлний зөв бичлэгийг нь дагаж жигдлэв. Жишээ нь Гул, Гуль, Гүл, Гүли гэх мэт хувилбараас Гүл ᠭᠦᠯ, Бахад, Бахит, Бахийт, Бакит, Бакыт, Бахыт, Бахт гэх мэт хувилбараас Бахыт ᠪᠠᠬᠢᠶᠢᠲᠦ гэх мэтээр жигдэлж бичив.
 35. Айымбол, Айымгүл гэх нэрсийн “айы” үеийг буулгахдаа дуудлагыг даган “ᠠᠶᠢ” үсэг жийрэглэн “ᠠᠶᠢᠮᠣᠪᠣᠯ” гэж бичив.
 36. Ауысхан, Дауытбек, Тауых, Хауыг гэх нэрсийн “ауы” үеийг буулгахдаа дуудлагыг даган “ᠠᠶᠢ” үсэг жийрэглэн “ᠠᠶᠢᠮᠣᠪᠣᠯ” гэж бичив.
 37. Ауез, Науетхан, Мауегүл, Тауекел гэх нэрсийн “ауе” үеийг буулгахдаа дуудлагыг даган “ᠠᠶᠢ” үсэг жийрэглэн “ᠠᠶᠢᠮᠣᠪᠣᠯ” гэж бичив.
 38. Балсая, Жансая, Дарига, Фатиха гэх мэт нэрд орхиц “а” бичиж ирснээс татгалзаж сүүлээр төгсгөж бичив. Ингэснээр тухайн үгийг бичлэгээс нь гадаад үг гэдэг нь танигдаж, улмаар зөв дуудах боломжтой болох юм. Цаашид ч энэ зарчмыг барих юм.
 39. Хятад нэрийг хөрвүүлэхдээ хятад хэлний үеийг монгол бичгээр буулган бичиж ирсэн уламжлалт зарчмыг (Сүмбэрбат “Хятад монгол толь”, Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин., 2011) барив.
 40. “Aizihaya, Alatenghuyige, Aode, Degjirefu, Enhebayaer, Nailun, Jirigalasaihan, Nimahu, Qinzhaorige, Sarenhu, Tiemulin” гэх нэрс нь хятад үсгээр тэмдэглэсэн монгол нэрийн латин галиг болох тул “Аззаяа, Алтанхуяг, Од, Дэгжрэх, Энхбаяр, Халиун, Жаргалсайхан, Нямхүү, Чинзориг, Саранхүү, Тэмүүлэн” хэмээн монгол нэрээр хөрвүүлэв.